**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дорноговь аймгийн Сайншанд сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДГА-2023/170/НА-СТА-ТШЗ**


| | | |
|---|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Сайншанд<br>2022 он | Тэргүүлэх аудитор: | Т.Ган-Өлзий |
| | Утас: 70522734 | Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn |
| | Аудитын менежер: | У.Оюунтүлхүүр |
| | Утас: 70523020 | Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn |
| | Ахлах аудитор: | Л.Равдандорж |
| | | Цахим хаяг: ravdandorjl@audit.gov.mn |
| | Аудитор: | М.Дүүрэнжаргал |
| | | Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/206

танай ______________-ны №______________-т

САЙНШАНД СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
А.АРИУНАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын 2-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, хөрөнгийн үр ашигтай зарцуулалт, баримтжуулалт хөрөнгө зарцуулалтын ил тод байдал, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион

010020044

байгуулсан эсэх, хөрөнгийн удирдлага зохион байгуулалт зэргийг гол асуудал гэж үзлээ.

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад хөрөнгө зарцуулах тухай 6 тушаалыг хугацаа хоцроож, 7 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Ebarimt-ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 50 ширхэг 49 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтуудыг хөөн шалгахад 16 ширхэг 5.0 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно". Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна. Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 87.8 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **77,153,917.11** | **148,843,679.15** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **12,846,337.07** | **86,007,839.21** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **12,846,337.07** | **86,007,839.21** |
| **31210** | **Төгрөг** | **12,846,337.07** | **86,007,839.21** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 1,833,902.18 | 69,524,804.32 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 11,012,434.89 | 16,483,034.89 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **64,307,580.04** | **62,835,839.94** |
| **35100** | **Түүхий эд материал** | **7,588,463.00** | **7,701,345.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,770,645.00 | 7,070,645.00 |
| 35130 | Эм боох материал | 817,818.00 | 630,700.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **56,719,117.04** | **55,134,494.94** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,131,395.00 | 2,633,778.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 39,578,542.04 | 39,571,093.94 |
| 35450 | Барилгын засварын материал | 6,962,967.00 | 4,433,501.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,619,924.00 | 3,648,950.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,426,289.00 | 4,847,172.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **668,483,683.35** | **773,814,908.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **668,483,683.35** | **773,814,908.20** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **616,244,016.47** | **722,006,991.24** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 702,243,578.69 | 863,144,563.69 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -138,151,369.29 | -177,706,635.51 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 81,596,938.00 | 81,596,938.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -42,017,098.15 | -54,962,448.40 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,148,295.40 | 34,148,295.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,753,286.32 | -29,500,631.40 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 9,529,151.28 | 9,529,151.28 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -4,795,343.14 | -5,685,391.82 |
| 39217 | Ном | 1,443,150.00 | 1,443,150.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **52,239,666.88** | **51,807,916.96** |
| 39301 | Програм хангамж | 1,727,000.00 | 1,727,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,151,333.12 | -1,583,083.04 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 51,664,000.00 | 51,664,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **745,637,600.46** | **922,658,587.35** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **65,933.10** | **758,450.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **65,933.10** | **758,450.00** |
| **41300** | **Өглөг** | **65,933.10** | **758,450.00** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 65,933.10 | 0.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **0.00** | **758,450.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 731,450.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.00 | 27,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **745,571,667.36** | **921,900,137.35** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **745,571,667.36** | **921,900,137.35** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 201,519,283.44 | 201,519,283.44 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 201,519,283.44 | 201,519,283.44 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **541,200,630.56** | **717,529,100.55** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -189,977,936.92 | 541,200,630.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 731,178,567.48 | 176,328,469.99 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,851,753.36 | 2,851,753.36 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **745,637,600.46** | **922,658,587.35** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,228,834,943.40** | **783,965,914.36** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **781,265,322.78** | **161,047,985.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **781,265,322.78** | **161,047,985.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,685,980.00** | **147,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 147,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,685,980.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 718,657,178.50 | 160,900,985.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 60,922,164.28 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **447,569,620.62** | **622,917,929.36** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **384,254,200.00** | **570,149,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 384,254,200.00 | 570,149,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **243,500.00** | **0.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,500.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 140,000.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **63,071,920.62** | **52,768,429.36** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 63,071,920.62 | 52,768,429.36 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **497,349,705.62** | **607,637,444.37** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **497,349,705.62** | **607,637,444.37** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **494,134,705.62** | **600,208,044.37** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **307,958,490.09** | **379,393,041.73** |
| 210101 | Үндсэн цалин | 256,611,017.09 | 287,831,017.27 |
| 210102 | Нэмэгдэл | 48,815,585.00 | 83,931,418.46 |
| 210104 | Урамшуулал | 2,531,888.00 | 7,630,606.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **39,126,174.82** | **47,807,073.03** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,962,425.66 | 32,930,492.22 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,050,537.92 | 3,854,757.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,440,390.33 | 3,066,185.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 606,665.55 | 723,076.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,066,155.36 | 7,232,562.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **41,327,205.62** | **47,368,429.36** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,139,771.62 | 7,500,491.36 |
| 210302 | Түлш, халаалт | 31,358,250.00 | 34,797,448.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,829,184.00 | 5,070,490.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,039,964.04** | **5,429,268.10** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,191,750.00 | 2,921,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 56,398.00 | 0.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,291,816.04 | 2,507,618.10 |
| **2105** | **Нормативт зардал** | **37,405,415.20** | **47,786,054.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 91,906.00 | 125,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 37,313,509.20 | 47,499,724.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 161,030.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,967,550.00** | **7,929,466.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,200,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,767,550.00 | 7,929,466.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **962,000.00** | **838,500.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 962,000.00 | 838,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **59,347,905.85** | **63,656,212.15** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,902,101.00 | 7,891,452.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 893,000.00 | 195,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 51,552,804.85 | 55,569,760.15 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,215,000.00** | **7,429,400.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,215,000.00** | **7,429,400.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,215,000.00 | 7,429,400.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **731,485,237.78** | **176,328,469.99** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **306,670.30** | **0.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 306,670.30 | 0.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **731,178,567.48** | **176,328,469.99** |

4417144353
ЕЮА0056 9025707

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **462,432,055.51** | **635,964,929.36** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,105,934.89** | **13,047,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **15,105,934.89** | **13,047,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **15,105,934.89** | **147,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 243,500.00 | 147,000.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 14,862,434.89 | 0.00 |
| 120009 | Бусад орлого | 0.00 | 12,900,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **447,326,120.62** | **622,917,929.36** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **384,254,200.00** | **570,149,500.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 384,254,200.00 | 570,149,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **63,071,920.62** | **52,768,429.36** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 63,071,920.62 | 52,768,429.36 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **449,585,718.44** | **562,803,427.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **449,585,718.44** | **562,803,427.22** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **446,370,718.44** | **555,403,427.22** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **311,051,892.00** | **392,331,974.83** |
| 210101 | Үндсэн цалин | 256,937,818.99 | 301,023,469.89 |
| 210102 | Нэмэгдэл | 49,759,309.01 | 83,690,875.54 |
| 210104 | Урамшуулал | 4,354,764.00 | 7,617,629.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **39,126,174.82** | **47,807,073.03** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,962,425.66 | 32,930,492.22 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,050,537.92 | 3,854,757.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,440,390.33 | 3,066,185.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 606,665.55 | 723,076.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,066,155.36 | 7,232,562.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **41,327,205.62** | **47,368,429.36** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,139,771.62 | 7,500,491.36 |
| 210302 | Түлш, халаалт | 31,358,250.00 | 34,797,448.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,829,184.00 | 5,070,490.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **38,375,490.00** | **48,528,750.00** |
| 210502 | Хоол, хүнс | 38,375,490.00 | 48,528,750.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,900,000.00** | **5,400,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,900,000.00 | 5,400,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **962,000.00** | **853,500.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 962,000.00 | 853,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,627,956.00** | **13,113,700.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,877,956.00 | 10,553,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,750,000.00 | 2,560,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,215,000.00** | **7,400,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,215,000.00** | **7,400,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,215,000.00 | 7,400,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **12,846,337.07** | **73,161,502.14** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **12,846,337.07** | **73,161,502.14** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 12,846,337.07 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 12,846,337.07 | 86,007,839.21 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **201,519,283.44** | **472,112,831.17** | **-670,942,114.61** | **2,690,000.00** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **201,519,283.44** | **472,112,831.17** | **-670,942,114.61** | **2,690,000.00** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.00** | **-469,261,077.81** | **480,964,177.69** | **11,703,099.88** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **731,178,567.48** | **731,178,567.48** |
| **10** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **201,519,283.44** | **2,851,753.36** | **541,200,630.56** | **745,571,667.36** |
| **11** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **201,519,283.44** | **2,851,753.36** | **541,200,630.56** | **745,571,667.36** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **201,519,283.44** | **2,851,753.36** | **541,200,630.56** | **745,571,667.36** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 176,328,469.99 | 176,328,469.99 |
| **20** | **2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл** | **201,519,283.44** | **2,851,753.36** | **717,529,100.55** | **921,900,137.35** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **572,130,400.00** | **502,605,597.86** | **69,524,802.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **572,130,400.00** | **502,605,597.86** | **69,524,802.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **572,130,400.00** | **502,605,597.86** | **69,524,802.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **451,232,500.00** | **392,331,974.83** | **58,900,525.17** |
| 210101 | Үндсэн цалин | 314,798,500.00 | 301,023,469.89 | **13,775,030.11** |
| 210102 | Нэмэгдэл | 128,332,400.00 | 83,690,875.54 | **44,641,524.46** |
| 210104 | Урамшуулал | 8,101,600.00 | 7,617,629.40 | **483,970.60** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **56,403,400.00** | **47,807,073.03** | **8,596,326.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,406,600.00 | 32,930,492.22 | **5,476,107.78** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,499,300.00 | 3,854,757.08 | **644,542.92** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,599,300.00 | 3,066,185.07 | **533,114.93** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 899,700.00 | 723,076.60 | **176,623.40** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,998,500.00 | 7,232,562.06 | **1,765,937.94** |
| **2105** | **Нормативт зардал** | **50,261,100.00** | **48,528,750.00** | **1,732,350.00** |
| 210502 | Хоол, хүнс | 50,261,100.00 | 48,528,750.00 | **1,732,350.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **853,500.00** | **853,500.00** | **0.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 853,500.00 | 853,500.00 | **0.00** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **13,379,900.00** | **13,084,300.00** | **295,600.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,819,300.00 | 10,523,700.00 | **295,600.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,560,600.00 | 2,560,600.00 | **0.00** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **572,130,400.00** | **570,296,500.00** | **1,833,900.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **570,149,500.00** | **570,149,500.00** | **0.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 570,149,500.00 | 570,149,500.00 | **0.00** |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **1,980,900.00** | **147,000.00** | **1,833,900.00** |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 147,000.00 | 147,000.00 | **0.00** |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 1,833,900.00 | 0.00 | **1,833,900.00** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 1,833,902.18 | **-1,833,902.18** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 69,524,804.32 | **-69,524,804.32** |

### 5.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд төлбөрийн акт тавигдаагүй болно.

### 5.2 Албан шаардлага

Тайлант хугацаанд албан шаардлага тогтоогоогүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

*Илрүүлэлт 1*: Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд Хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн буюу өмнөх онтой харьцуулбал 39% иар, нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дахь хэсэгт шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэж заасныг зөрчиж байна.

*Өгсөн зөвлөмж 1*: Холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах

*Илрүүлэлт 2*: Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход 2,3, жил гэсэн хугацаа ашиглагдаж байна.

Энэ нь БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна.

*Өгсөн зөвлөмж 2*: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон бусад хууль, журам заавруудыг мөрдөж ажиллах

*Илрүүлэлт 3*: Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд богино хугацаат өр төлбөрийг 4 дахин нэмэгдүүлсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 6.4.8-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно гэсэн заалттай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж 3*: Бараа материалыг актлах бүрд тушаал шийдвэр гаргуулах санхүүгийн тайланд тусган ажиллах

*Илрүүлэлт 4*: Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай 6 тушаалыг хугацаа хоцроож 7 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж 4*: А тушаал гарах тухай бүрд шилэн дансанд мэдээлж ажиллах

*Илрүүлэлт 5*: Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС

болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 50 ширхэг 49 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 16 ширхэг 5.0 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасны дагуу хяналт тавьж арга хэмжээ аваагүй байна. Мөн тохиолдсон байх, зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж 5*: И баримтын дүнг тухай бүрд өөрийн байгууллагын бүртгэлтэй тулгаж бодитоор ажил гүйлгээ гараагүй И баримт гарах тухайн харилцагч байгууллагад мэдэгдэж буцаалтыг баталгаажуулж санхүүгийн бүртгэлдээ үнэн зөв баримтыг тусган ажиллах

*Илрүүлэлт 6:*Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар тендерийн ялагчгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь тус хуулийн 30.4-т заасан шууд гэрээ байгуулах нөхцөлийг бүрэн хангаагүй байна.30.4.1.тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;30.4.2.энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах; 30.4.3.энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах

*Өгсөн зөвлөмж 6:* 10.0 сая-с дээш үнийн дүн бүхий Бараа материал худалдан авахдаа дээрх хуулиудын дагуу худалдан авалтыг хийж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2023 оны санхүүгийн тайлангаар илэрсэн нийт алдаа зөрчлийн нэгтгэл | 1 | 12,900.0 | | | 1 | 12,900.0 | 1 | 12,900.0 | | | | |
| **ДҮН** | 1 | 12,900.0 | | | **1** | **12,900.0** | **1** | **12,900.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд Хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлсөн буюу өмнөх онтой харьцуулбал 39% иар, нэмэгдүүлсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дахь хэсэгт шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх гэж заасныг зөрчиж байна. | 1 | 3,649.0 | | | 1 | 3,649.0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход 2,3, жил гэсэн хугацаа ашиглагдаж байгаа нь БШУЯ болон түүний харьяа байгууллагуудын мөрдөж буй бодлогын баримт бичигт заасан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаатай тохирохгүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | |
| Санхүүгийн байдлын тайлангийн мэдээлэлд эдийн засгийн шинжилгээ хийж үзэхэд богино хугацаат өр төлбөрийг 4 дахин нэмэгдүүлсэн байна. | 1 | 758.5 | | | 1 | 758.5 | | | | |
| **ДҮН** | **3** | **4,407.5** | | | **3** | **4,407.5** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай Хөрөнгө зарцуулах тухай 6 тушаалыг хугацаа хоцроож 7 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй байна. | 1 | 29,409.6 | | | | | 1 | 29,409.6 |
| **ДҮН** | **1** | **29,409.6** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **29,409.6** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Ebarimt- ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 50 ширхэг 49 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 16 ширхэг 5.0 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. | **1** | **5,017.0** | | | | | **1** | **5,017.0** |
| Тайлант жилийн худалдан авах ажиллагааны тендерийг зохион байгуулахдаа Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1-т зааснаар шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй гэдэг шалтгаанаар шууд худалдан авалт хийсэн байна. | 1 | **47,270.8** | | | | | 1 | 47,270.8 |
| **ДҮН** | **2** | **52,287.8** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **52,287.8** |